

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/161/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

додд. 02. 05 № УВА-додд/161/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

ХЯРГАС СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.БАЛЖИННЯМ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200177

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,242,818.73</u>	<u>25,368,341.67</u>
33	АВЛАГА	1,011,267.73	315,306.00
335	Бусад авлага	1,011,267.73	315,306.00
3351	Байгууллагаас авах авлага	1,011,267.73	315,306.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,231,551.00	25,053,035.67
354	Хангамжийн материал	19,231,551.00	25,053,035.67
35410	Бичиг хэргийн материал	39,275.00	592,975.00
35420	Аж ахуйн материал	19,192,059.00	24,228,059.00
35440	Түлш, шатах тослох материал	217.00	01.67
35470	Бусад хангамжийн материал	00.00	232,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>482,295,853.62</u>	<u>483,487,017.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	482,295,853.62	483,487,017.10
392	Биет хөрөнгө	478,371,853.62	479,661,117.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	397,073,530.00	397,073,530.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,086,699.92	-59,121,556.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,978,449.67	34,988,647.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,967,416.31	-25,487,144.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,351,567.00	25,121,567.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,568,176.46	-14,696,526.32
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	92,729,860.00	92,729,860.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,000,000.00	18,012,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,336,666.52	-5,156,666.44
39217	Ном	16,197,406.16	16,197,406.16
393	Биет бус хөрөнгө	3,924,000.00	3,825,900.00
39301	Программ хангамж	172,600.00	172,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-172,600.00	-172,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,924,000.00	3,924,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-98,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>502,538,672.35</u>	<u>508,855,358.77</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>502,538,672.35</u>	<u>508,855,358.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	502,538,672.35	508,855,358.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	330,547,288.83	330,547,288.83
51101	Өмч: - төрийн	330,547,288.83	330,547,288.83
512	Хуримтлагдсан үр дүн	-87,369,081.28	-81,052,394.86
51210	Өмнөх үеийн үр дүн	-87,369,081.28	-87,369,081.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,316,686.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	259,360,464.80	259,360,464.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>502,538,672.35</u>	<u>508,855,358.77</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	122,237,408.00	122,496,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,300,708.00	17,380,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,300,708.00	17,380,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,300,708.00	17,380,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	4,831,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,200,708.00	12,549,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,936,700.00	105,116,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,936,700.00	105,116,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,936,700.00	105,116,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	131,089,557.64	116,180,213.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,089,557.64	116,180,213.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,639,167.40	114,060,468.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,668,069.00	58,765,210.00
210101	Үндсэн цалин	54,648,281.00	58,765,210.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,019,788.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,880,573.76	8,029,006.29
210201	Тэтгэврийн даатгал	3,441,959.89	8,029,006.29
210202	Тэтгэмжийн даатгал	609,828.47	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	488,143.18	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,685.29	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,218,956.93	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,552,743.00	31,680,713.90
210301	Гэрэл, цахилгаан	425,793.00	425,700.00
210302	Түлш, халаалт	27,998,950.00	31,255,013.90
210303	Цэвэр, бохир ус	128,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,553,865.00	805,701.43
210401	Бичиг хэрэг	845,425.00	177,000.00
210402	Тээвэр, шатахуун	564,940.00	310,201.43
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	783,500.00	118,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,607,380.00	2,486,000.00
210604	Урсгал засвар	1,607,380.00	2,486,000.00
2107	Томилолт, зочны зардал	233,000.00	126,000.00
210702	Дотоод албан томилолт	233,000.00	126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	438,800.00	216,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	348,800.00	00.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,704,736.64	11,951,836.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,704,736.64	11,951,836.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,450,390.24	2,119,745.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,476,200.00	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,326,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	974,190.24	1,919,745.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,852,149.64	6,316,686.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,852,149.64	6,316,686.42

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	120,036,700.00	105,116,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,936,700.00	105,116,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,936,700.00	105,116,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,936,700.00	105,116,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	120,036,700.00	105,116,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,036,700.00	105,116,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,436,309.76	102,997,154.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,536,300.00	58,913,230.00
210101	Үндсэн цалин	52,496,300.00	53,938,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,974,530.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,735,486.76	7,185,024.56
210201	Тэтгэврийн даатгал	4,296,872.88	4,978,378.56
210202	Тэтгэмжийн даатгал	609,827.47	551,662.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	488,144.18	441,329.77
210204	Ажилгүйдлийн даатгал	121,685.29	110,332.48
210205	Эрүүл мэндийн даатгал	1,218,956.94	1,103,321.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,552,743.00	31,680,500.00
210301	Гэрэл, цахилгаан	425,793.00	425,700.00

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	27,998,950.00	31,254,800.00
210303	Цэвэр, бохир ус	128,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,290,100.00	909,400.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	203,700.00
210402	Тээвэр, шатахуун	465,100.00	310,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,000.00	145,500.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,929,880.00	2,368,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	82,000.00
210604	Урсгал засвар	1,599,880.00	2,286,000.00
2107	Томилолт, зочны зардал	233,000.00	126,000.00
210702	Дотоод албан томилолт	233,000.00	126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	658,800.00	1,715,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	568,800.00	1,499,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,600,390.24	2,119,745.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,626,200.00	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,326,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	974,190.24	1,919,745.44

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	330,547,288.83	167,960,519.80	-38,515,249.07	459,992,559.56
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,547,288.83	167,960,519.80	-38,515,249.07	459,992,559.56
С04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
С05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,287,896.34	-10,287,896.34
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	330,547,288.83	259,360,464.80	-87,369,081.28	502,538,672.35
D01	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	330,547,288.83	259,360,464.80	-87,369,081.28	502,538,672.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,547,288.83	259,360,464.80	-87,369,081.28	502,538,672.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,316,686.42	6,316,686.42
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	330,547,288.83	259,360,464.80	-81,052,394.86	508,855,358.77

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,116,900.00	103,197,154.56	1,919,745.44	98.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,116,900.00	103,197,154.56	1,919,745.44	98.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,866,900.00	102,997,154.56	1,869,745.44	98.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,673,600.00	58,913,230.00	1,760,370.00	97.10
210101	Үндсэн цалин	55,633,600.00	53,938,700.00	1,694,900.00	96.95
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,974,530.00	65,470.00	98.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,191,000.00	7,185,024.56	1,005,975.44	87.72
210201	Тэтгэврийн даатгал	5,764,000.00	4,978,378.56	785,621.44	86.37
210202	Тэтгэмжийн даатгал	606,700.00	551,662.25	55,037.75	90.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	485,400.00	441,329.77	44,070.23	90.92
210204	Ажилгүйдлийн даатгал	121,400.00	110,332.48	11,067.52	90.88
210205	Эрүүл мэндийн даатгал	1,213,500.00	1,103,321.50	110,178.50	90.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,808,500.00	31,680,500.00	128,000.00	99.60
210301	Гэрэл, цахилгаан	425,700.00	425,700.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	31,254,800.00	31,254,800.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	128,000.00	00.00	128,000.00	0.00

2104	Хангамж, бараа материалын зардал	910,300.00	909,400.00	900.00	99.90
210401	Бичиг хэрэг	204,100.00	203,700.00	400.00	99.80
210402	Тээвэр, шатахуун	310,200.00	310,200.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	200,000.00	200.00	99.90
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	145,500.00	300.00	99.79
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,310,000.00	2,368,000.00	-1,058,000.00	180.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	00.00	83,700.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	82,000.00	1,300.00	98.44
210604	Урсгал засвар	1,143,000.00	2,286,000.00	-1,143,000.00	200.00
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	126,000.00	7,500.00	94.38
210702	Дотоод албан томилолт	133,500.00	126,000.00	7,500.00	94.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,000.00	1,715,000.00	25,000.00	98.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,524,000.00	1,499,000.00	25,000.00	98.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00	200,000.00	50,000.00	80.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	200,000.00	50,000.00	80.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00	50,000.00	80.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105,116,900.00	105,116,900.00	0.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,116,900.00	105,116,900.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	105,116,900.00	105,116,900.00	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хяргас сумын Соёлын төв нь “Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж, түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж, соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж, өвлүүлэн үлдээхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 0.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 111.7 сая төгрөгийн 1 хувь буюу 1.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 508,855.3 мянган төгрөг буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,011.2	315.3	695.9
Бараа материал	19,231.2	25,053.0	5,821.4
Үндсэн хөрөнгө	482,295.8	483,487.0	1,191.2
Нийт хөрөнгө	502,538.6	508,855.3	6,316.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	502,538.6	508,855.3	6,316.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	502,535.6	508.855.3	6,316.6

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 315.3 мянган төгрөг болж 695.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,053.0 мянган төгрөг болж 5,821.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бичиг хэрэг, аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 483,487.0 мянган төгрөг болж 1,191.2 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлого авсантай холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 508,855.3 мянган төгрөг болж 6,316.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 122,496.9 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 116,180.2 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар буурсан байна. Энэ нь хангамж бараа материал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд буурсантай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хяргас сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 116,075.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 116,075.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10,959.0 мянган төгрөгөөр бууруулж 105,116.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 105,116.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 105,116.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 105,116.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 102,997.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 102,997.1 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Хяргас сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 126, хугацаа хоцроосон 23 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шилэн дансны мэдээллийг анхаарч үзэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 21-ний өдөр